



БАТЛАВ,
ГҮЙЦЭТГЭГЧ:
"АТТА ЧР" ХХК-ийн
ЗАХИРАЛ

С. ПҮРЭВДОРЖ

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2019 оны 6 дугаар
сарын 19-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 43

Нэг талаас Онцгой байдлын ерөнхий газар, түүнийг төлөөлж тус газрын Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын дарга, дэд хурандаа Я.Гантөмөр, (цаашид "Захиалагч" гэх), нөгөө талаас "Атта Чр" ХХК, түүнийг төлөөлж тус компанийн ерөнхий менежер ажилтай Б.Баттөр (цаашид "Гүйцэтгэгч" гэх) нар 2018 оны Улсын төсвийг үндэслэн харилцан тохиролцож, 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдөр энэхүү Гэрээг байгуулав.

1. Гэрээний дүн: 74,048,609 /далан дөрвөн сая дөчин найман мянга зургаан зуун есөтөгөр.
2. 2019 оны төсвөөс тооцож ажлын гүйцэтгэлээр нь санхүүжүүлнэ.
3. Гүйцэтгэгчийн Гэрээгээр гүйцэтгэх ажил: Онцгой байдлын ерөнхий газрын 2 дугаар давхрын дотор засварын ажил.
4. Энэхүү Гэрээгээр гүйцэтгэж буй барилгын засварын ажлыг хуанлын 30 хоногт хийж гүйцэтгэх бөгөөд ажил дуусах хугацааг 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдөр, гэрээ дуусах хугацааг 2019 оны 07 дугаар сарын 31-ны өдрөөр тус тус тогтоон.
5. Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний ерөнхий нөхцөлийн 17-д заасныг үндэслэн ирүүлсэн үе шатны ажлын хуваарийг баримтлан, ажлыг Гэрээний хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэж хүлээлгэн өгөх.
6. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид "Гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

5.1	Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл,
5.2	Гүйцэтгэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ,
5.3	Гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрөл /гэрчилгээ, хавсралтын хамт,
5.4	Гэрээний тусгай нөхцөл,
5.5	Гэрээний ерөнхий нөхцөл,
5.6	Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь.
7. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон угсан холбоогоор харилцана.

10/100 (2019.06.19)

ИЛТГЭХ ХУУДАС

2019 он 06 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал танаа харьцуулалтын тендер шалгаруулалт явуулсан тухай ИЛТГЭХ нь.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйл, 47 дугаар зүйлийн 47.1-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын төв байрны 2 дугаар давхрын засварын ажил гүйцэтгэх гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ОБЕГТ01904049 дугаар бүхий харьцуулалтын тендер шалгаруулалтыг үндэсний өдөр тутмын "Зууны мэдээ" сонин болон tender.gov.mn сайтад зарласан.

Тендер шалгаруулалтын урилгад заасан хугацаанд "Атта чр" ХХК болон "Эс Жи Эм" ХХК нар тендерийн материал ирүүлсэн.

Тендер шалгаруулалтын үнэлгээ хийж байх явцад "Эс Жи Эм" ХХК нь тендэрт шалгарсан тохиолдолд тухай ажлыг гүйцэтгэх боломжгүй тул тендерийн сонгон шалгаруулалтаас татгалзаж байгаа тухай хүсэлт ирүүлсэн.

Иймд "Эс Жи Эм" ХХК-ийн ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, Төрийн болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2-т заасны дагуу "Атта Чр" ХХК-д Гэрээ байгуулах эрх олгох саналтай байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Т.БАДРАЛ

19.06.19.06.15
Т.Бадрал

САНХҮҮ, ХАНГАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА Я.ГАНТӨМӨР

ИЛТГЭХ ХУУДАС БАИЦСЭН:
БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ТАСВИЙН ДАРГА,
ХОШУУЧ Т.ГАЛБАДРАХ

Т.Галбадрах